

Б-СӨБ-2 тайлангийн маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

Б-СӨБ-2 тайлангийн маягтын үзүүлэлтийг системээс гаргах зааварчилгаа

1. Үндсэн сургалтад хамрагдаж байгаа хүүхэд болон бүлгийг тоолохдоо

Боловсролын удирдлагын системийн “Сургалтын хөтөлбөр” үйл ажиллагааны “Хөтөлбөрийн төрөл (Program type) талбар нь СӨБ-Сургуулийн өмнөх боловсрол-Хувилбарт” гэсэн сонголтоос бусад хөтөлбөр сонгогдсон, сургалтын хэлбэр (Academic shift) талбар нь Үндсэн гэж сонгогдсон, “Анги, бүлэг” үйл ажиллагааны Бүлгийн ангилал (Group student classification) талбар нь үндсэн бүлэг гэж сонгогдсон дараах бүлэг болон бүлэгт суралцаж байгаа суралцагч

- Хамран сургах тойргийн хүүхэд үзүүлэлтэд: Боловсролын удирдлага системийн Суралцагчийн хувийн мэдээллийн Нэмэлт мэдээлэл-Өрхийн мэдээлэл хэсэгт хамран сургах тойргийн эсэх талбарт Тийм (чеклэсэн) суралцагчийг тоолно.
- Хамран сургах тойргийн бус хүүхэд үзүүлэлтэд: Боловсролын удирдлага системийн Суралцагчийн хувийн мэдээллийн Нэмэлт мэдээлэл-Өрхийн мэдээлэл хэсэгт хамран сургах тойргийн эсэх талбарт Үгүй (чеклээгүй) суралцагчийг тоолно.

2. Хувилбарт сургалтад хамрагдаж байгаа хүүхэд болон бүлгийг тоолохдоо

Боловсролын удирдлагын системийн “Сургалтын хөтөлбөр” үйл ажиллагааны “Хөтөлбөрийн төрөл (Program type) талбар нь СӨБ-Сургуулийн өмнөх боловсрол-Хувилбарт” гэж сонгогдсон, сургалтын хэлбэр (Academic shift) талбар нь Хувилбарт гэж сонгогдсон дараах бүлэг болон бүлэгт суралцаж байгаа суралцагч

- Хамран сургах тойргийн хүүхэд үзүүлэлтэд: Боловсролын удирдлага системийн Сургалтын бүтэц үйл ажиллагааны салбар бүрэлдэхүүн таб дахь цэцэрлэгийн нэр дээр дарж ороод хамран сургах тойрогтой эсэх талбарт Тийм (чеклэсэн) гэж хариулсан, Суралцагчийн хувийн мэдээллийн Нэмэлт мэдээлэл-Өрхийн мэдээлэл хэсэгт хамран сургах тойргийн эсэх талбарт Тийм (чеклэсэн) суралцагчийг тоолно.
- Хамран сургах тойргийн бус хүүхэд үзүүлэлтэд: Хамран сургах тойрогтой цэцэрлэгт суралцаж буй суралцагчийн хамран сургах тойргийн эсэх талбарыг чеклээгүй, мөн хамран сургах тойроггүй цэцэрлэгийн суралцагчийг тоолно.

3. Бүтэн цагийн гэдэгт

Суралцагчийн хөтөлбөрийн сургалтын ачаалал нь Бүтэн цаг гэж сонгогдсон, суралцагч бүрийг насаар тоолно.

Нэг бүлэгт суралцаж байгаа суралцагчийн ядаж нэг суралцагч Бүтэн цаг гэсэн сургалтын ачаалал сонгогдсон бол бүтэн цагийн нэг бүлэг байна гэж тоолно.

4. Цагийн гэдэгт

Суралцагчийн хөтөлбөрийн сургалтын ачаалал нь Цагийн гэж сонгогдсон суралцагч бүрийг насаар тоолно.

Нэг бүлэгт суралцаж байгаа суралцагчийн ядаж нэг суралцагч Цагийн гэсэн сургалтын ачаалал сонгогдсон бол Цагийн нэг бүлэг байна гэж тоолно.

5. Уртасгасан цагийн гэдэгт

Суралцагчийн хөтөлбөрийн сургалтын ачаалал нь Бүтэн цаг гэж сонгогдсон суралцагч бүрийг насаар тоолно.

Нэг бүлэгт суралцаж байгаа суралцагчийн ядаж нэг суралцагч Уртасгасан цаг гэсэн сургалтын ачаалал сонгогдсон бол уртасгасан цагийн нэг бүлэг байна гэж тоолно.

6. Богиносгосон цагийн гэдэгт

Суралцагчийн хөтөлбөрийн сургалтын ачаалал нь Богиносгосон цаг гэж сонгогдсон суралцагч бүрийг насаар тоолно.

Нэг бүлэгт суралцаж байгаа суралцагчийн ядаж нэг суралцагч Богиносгосон цаг гэсэн сургалтын ачаалал сонгогдсон бол богиносгосон цагийн нэг бүлэг байна гэж тоолно.

7. 24 цагийн бүлэгт гэдэгт

Суралцагчийн хөтөлбөрийн сургалтын ачаалал нь 24 цаг гэж сонгогдсон суралцагч бүрийг насаар тоолно.

Нэг бүлэгт суралцаж байгаа суралцагчийн ядаж нэг суралцагч 24 цаг гэсэн сургалтын ачаалал сонгогдсон бол 24 цагийн нэг бүлэг байна гэж тоолно.

Хэрэв суралцагчийн сургалтын ачааллыг буруу оруулсан бол Боловсролын удирдлагын системийн Суралцагчийн хувийн мэдээллийн хөтөлбөр төлөвлөгөө хэсгийн мэдээлэл засах үйлдлээр орж сургалтын ачаалал талбарын мэдээллийг өөрчлөн засаж хадгалах боломжтой. Мэдээллийг өөрчилж зассан бол статистикийн систем руу орж мэдээллийг шинэчлэх үйлдлийг заавал хийж, тайлан бодуулж тайланг эксэл рүү гаргаж шалгана.

8. Гэрт байрладаг

Бүлгийн өрөөний Анги танхим талбарт Гэрийг сонгосон, тухайн бүлэг суралцагчтай, анги, бүлэг удирдсан багштай байх.

Гэрийг бүртгэхдээ Боловсролын удирдлагын системийн Сургалтын орчин үйл ажиллагааны Байр таб-д шинэ байр үйлдлээр гэрийг бүртгэсэн, өрөө таб-д шинэ өрөө үйлдлээр байр таб-д бүртгэсэн гэрийг өрөө болгож бүртгэсэн байх.

Нэг гэрийг нэгээс дээш өрөө үүсгэж бүртгэж болох боловч тухайн гэрт олон бүлэг хичээллэдэг бол гэрийг нэг гэж, бүлгийг сонгогдсон тоогоор тоолно.

Үүнээс:

8.1. Үндсэн

Боловсролын удирдлагын системийн **"Сургалтын хөтөлбөр"** үйл ажиллагааны 'Хөтөлбөрийн төрөл (Program type) талбар нь СӨБ-Сүргүүлийн өмнөх боловсрол-Хувилбарт гэсэн сонголтоос бусад хөтөлбөр сонгогдсон, сургалтын хэлбэр (Academic shift) талбар нь Үндсэн гэж сонгогдсон, **"Анги, бүлэг"** үйл ажиллагааны Бүлгийн ангилал (Group student classification) талбар нь үндсэн бүлэг гэж сонгогдсон гэрт байрладаг бүлэг болон бүлэгт суралцаж байгаа суралцагчийг насаар тоолно.

Үүнээс:

8.2. Хувилбарт

Боловсролын удирдлагын системийн **"Сургалтын хөтөлбөр"** үйл ажиллагааны 'Хөтөлбөрийн төрөл (Program type) талбар нь СӨБ-Сүргүүлийн өмнөх боловсрол-Хувилбарт гэж сонгогдсон, сургалтын хэлбэр (Academic shift) талбар нь Хувилбарт гэж сонгогдсон гэрт байрладаг бүлэг болон бүлэгт суралцаж байгаа суралцагчийг насаар тоолно.

9. Салбар бүлэгт

Боловсролын удирдлагын системийн Анги, бүлэг үйл ажиллагааны бүлгийн хэлбэр талбар нь Салбар бүлэг гэж сонгогдсон бүлэгт суралцагчийг насаар тоолно.

Үүнээс:

9.1. Гэрт байрладаг

Боловсролын удирдлагын системийн Анги, бүлэг үйл ажиллагааны бүлгийн хэлбэр талбар нь Салбар бүлэг гэж сонгогдсон, бүлэг нь гэрт байрладаг, бүлэгт суралцагчийг насаар тоолно.

10. Хөгжлийн бэрхшээлтэй хүүхэд:

Боловсролын удирдлагын системийн Суралцагчийн хувийн мэдээллийн эрүүл мэнд хэсгийн хөгжлийн бэрхшээлийн хөгжлийн бэрхшээлтэй талбарт үгүй гэснээс бусад сонголт сонгогдсон суралцагчийг тоолно.

Үүнээс:

10.1. Үндсэн сургалт

Боловсролын удирдлагын системийн **"Сургалтын хөтөлбөр"** үйл ажиллагааны 'Хөтөлбөрийн төрөл (Program type) талбар нь СӨБ-Сүргүүлийн өмнөх боловсрол-Хувилбарт гэсэн сонголтоос бусад хөтөлбөр сонгогдсон, сургалтын хэлбэр (Academic shift) талбар нь Үндсэн гэж сонгогдсон, **"Анги, бүлэг"** үйл ажиллагааны Бүлгийн ангилал (Group student classification) талбар нь үндсэн бүлэг гэж сонгогдсон хөгжлийн бэрхшээлтэй суралцагч сурч байгаа бүлэг болон суралцагчийг насаар тоолно.